



Нийгмийн суурь үнэт зүйлсийн Олон улсын дүрэм

2020 оны хувилбар

JCDecaux

НИЙГМИЙН



Агуулга

захирлуудаас ирсэн мессеж

I Удиртгал

II Энэхүү дүрмийн зорилго

III Хамрах хүрээ

IV Үүрэг

- 4.1. Хамтын хэлэлцээ хийх болон Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө
- 4.2. Бүх төрлийн албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг устгах
- 4.3. Хүүхдийн хөдөлмөрийг устгах
- 4.4. Ажлын байранд ялгаварлан гадуурхахгүй байх
- 4.5. Ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй байдал
- 4.6. Ажлын өдөр болон Ажлын долоо хоногийн үргэлжлэх хугацаа
- 4.7. Шударга цалин хөлс авах эрх
- 4.8. Цалинтай амралт авах эрх
- 4.9. Сургалтад хамрагдах эрх
- 4.10. Бүх хэлбэрийн дарамт, хүчирхийллийг хориглох нь
- 4.11. Бүтцийн өөрчлөлт хийсэн тохиолдолд Ажилтнуудыг шилжүүлэн ажиллуулах
- 4.12. Хувийн нууц, Хувийн мэдээлэл хамгааллын асуудал
- 4.13. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцох эрх
- 4.14. Нийгмийн хамгаалалд хамрагдах эрх
- 4.15. Ажил-Хувийн амьдралын тэнцвэртэй байдал
- 4.16. Хувийн шалтгаанаар чөлөө авах
- 4.17. Шинээр мэндэлсэн хүүхэдтэй холбоотой хамгаалуулах эрх

V Дүрмийг хэрэгжүүлэх

- 5.1. Гүйцэтгэх зөвлөлийн үүрэг
- 5.2. Дүрмийг тараах
- 5.3. Орон нутгийн салбарын Менежментийн үүрэг хариуцлага
- 5.4. Мэдээлэл илгээх журам



захирлуудаас ирсэн мессеж

Бид 1964 оноос хойш өөрсдийн үйл ажиллагаандаа эрхэмлэн баримталж, дагаж мөрдөх үнэт зүйлсийг тодорхойлж, тэдгээр үнэт зүйлсийг дагаж мөрдөх байгууллагын дотоод соёлыг бий болгосон бөгөөд, энэ нь ЖэйСиДекогийн өнөөгийн ололт амжилт, нэр хүндийг бий болгосон юм. Бидний дагаж мөрдөх үнэт зүйлс гэдэг нь чухамдаа бидний цаашдын өсөлт хөгжилд хүмүүс үндсэн үүрэг гүйцэтгэдэг гэсэн санаа бөгөөд үүний учир бүх ажилтнуудаа аюулгүй, бие биеэ хүндэтгэдэг ажиллах орчноор хангахын төлөө үргэлж хичээн зүтгэсээр ирсэн билээ. Олон улсад хурдацтай өсөн тэлж буй үйл ажиллагаандаа нийгмийн суурь үнэт зүйлсийг дагаж мөрдөх нь юу юунаас илүү чухал болохыг ухамсарлан ойлгосны үндсэн дээр бид Группийн хэмжээнд үйл ажиллагаандаа баримтлах гарын авлага болгох үүднээс ЖэйСиДекогийн Нийгмийн суурь үнэт зүйлсийн Олон улсын дүрмийг боловсруулсан.

Өнөөдөр ЖэйСиДеко нь дэлхийн 55 гаруй улсад үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд бизнесийн төрөл бүрийн харилцан адилгүй орчин, соёлыг ойлгож, хүлээн зөвшөөрсөн билээ. Үүний зэрэгцээгээр бид нийгмийн суурь үнэт зүйлсийн хувьд нэгэн ижил зорилго тэмүүлэлтэй байж, өөрсдийн баримтлах стандарт болгон хэвшүүлж, биелүүлэхийн төлөө бүх талаар хөгжих нь хамгийн чухал юм.

Энэхүү Дүрмийг бид Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн Түгээмэл тунхаглал, Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн тухай тунхаг болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Үндэстэн дамнасан корпорациудад зориулсан гарын авлага гэх мэт олон улсын стандартын дагуу боловсруулсан болно. Энэхүү Дүрэм нь Группийн дотоод болон гадны бизнесийн хамтрагч нартай хамтран явуулах бизнесийн үйл ажиллагааг чиглүүлэх үүрэг бүхий ЖэйСиДекогийн Ёс зүйн дүрмийн хамтаар ЖэйСиДекогийн хүн ба байгаль орчинд ээлтэй эдийн засгийн хөгжлийн эрэлхийлэл хэмээн тодорхойлогдсон тогтвортой хөгжлийг хангах үүргийн гол багана болох юм.

Бид та бүгдийг энэхүү Дүрэмд заасан үнэт зүйлсийг дэмжиж, өөрсдийн зан үйл, үйлдэл бүрийнхээ амин зүрх болгоно гэдэгт найдаж байна. Энэ нь бидний зүгээс компанийнхаа цаашдын амжилт, урт хугацааны тогтвортой байдлыг хангахад өгөх хамгийн шилдэг баталгаа болох болно.

Жон-Франсуо Деко



Жон-Чарльз Деко





I | УДИРТГАЛ

ЖэйСиДекогийн ажилтнууд нь Компанийн хамгийн үнэтэй өв хөрөнгө бөгөөд тиймээс ч ажилтнуудаа аюулгүй, бие биеэ хүндэтгэдэг ажиллах орчноор хангах нь ЖэйСиДекогийн нэн тэргүүний зорилт билээ

II | Энэхүү дүрмийн зорилго

ЖэйСиДекогийн Нийгмийн суурь үнэт зүйлсийн Олон улсын дүрмээр ЖэйСиДеко Эс.Эй болон Группийн удирдлагад багтдаг бүхий л охин компаниудын хувьд баримтлах ёс зүйн үндсэн үндэс суурийг тодорхойлсон болно.

Энэхүү Дүрмийг боловсруулахдаа Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага (“ОУХБ”)-ын Суурь конвенциуд болон Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (“ЭЗХАХБ”)-аас гаргасан гарын авлагыг үндэс болгосон.



Хамрах хүрээ

ЖэйСиДекогийн Нийгмийн суурь үнэт зүйлсийн Олон улсын дүрэм нь ЖэйСиДекогийн Ёс зүйн дүрмийн хамтаар аль улсад ажиллаж байгаагаас үл хамаарч ЖэйСиДеко Группийн бүхий л ажилтнуудын эрх ашгийн төлөө үйлчлэх болно.

Гэвч хэрэв тухайн улсын хуульд ажилтнуудын нөхцөл байдлыг энэхүү Дүрэмд зааснаас илүү буюу дээрдүүлсэн зохицуулалт, журам бий бол тухайн улсын хууль нь үйл ажиллагаа явуулж буй улсын ЖэйСиДекогийн салбар нэгжийн үйл ажиллагаанд баримтлан дагаж мөрдөх хууль байх нь ойлгомжтой.

Энэ дүрэм нь тухайн улсын хууль тогтоомж, журамд нийцэхгүй, эсвэл нийтлэг практикт нь зөрчилдөж байвал тухайн орон нутгийн байгууллага энэхүү дүрмийн хэрэгжилтийг аль болох орон нутагт нь зөвшөөрөгдсөн, холбогдох харьяаллын хууль тогтоомжид нь нийцсэн байдлаар, мөн тэдгээр хууль, журам, практикийг чандлан дагаж мөрдөхөөр зохицуулах ёстой.

ЖэйСиДеко нь энэхүү Дүрэмд заасан үнэт зүйлсийг ЖэйСиДекогийн оролцогч талууд, тухайлбал ЖэйСиДеко хувь эзэмшдэг компаниуд, тэдгээрийн ханган нийлүүлэгчид, туслан гүйцэтгэгчид, түншүүд хэрэглэх явдлыг дэмжиж ажиллахад анхаарч байгаа болно. Тиймээс ЖэйСиДеко нь өөрийн бизнесийн үйл ажиллагаандаа эдгээр нийгмийн үнэт зүйлсийг хамгийн боломжит дээд хэмжээнд хэрэгжүүлэхийн төлөө оролцогч талуудтайгаа хамтран ажиллах болно.



IV | Үүрэг

4.1. Хамтын хэлэлцээ хийх эрх болон Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө

ЖэйСиДеко нь ОУХБ-ын 87 ба 98 дугаар Конвенцэд заасан хамтын хэлэлцээ хийх, эвлэлдэн нэгдэх эрх болон дор дурдсаныг багтаасан боловч эдгээрээр хязгаарлагдахгүй бусад эрхийг ч мөн хүндэтгэн үзнэ. Үүнд:

- › Эвлэл эсвэл бусад төрлийн байгууллага байгуулах буюу нэгдэн орох эрх;
- › Ажилтнууд өөрсдийн төлөөлөгчөө сонгох эрх; болон
- › Үйлдвэрчний эвлэлийн эрхээ чөлөөтэй эдлэх эрх болно.

4.2. Бүх төрлийн албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг устгах

ЖэйСиДеко нь ОУХБ-ын 29 ба 105 дугаар Конвенцэд заасны дагуу бүх төрлийн албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийг хориглож, албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн аливаа хэлбэрийг ашиглахгүй.

4.3. Хүүхдийн хөдөлмөрийг устгах

ЖэйСиДеко нь ОУХБ-ын 138 ба 182 дугаар Конвенцэд заасны дагуу хүүхдийн хөдөлмөрийг хориглож, тухайн улсад хуулиар бүрэн бус дунд боловсрол эзэмших наснаас доош буюу ямар ч тохиолдолд арван таван наснаас доош насны хүүхдийг ажиллуулахгүй гэдгээ хүлээн зөвшөөрч байна.

4.4. Ажлын байранд ялгаварлан, гадуурхахгүй байх

ЖэйСиДеко нь ОУХБ-ын 100 ба 111 дугаар Конвенцэд заасны дагуу хөдөлмөрийн харилцаанд аливаа ялгаварлан гадуурхах, алагчлах явдлыг устгаж, арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хүйс, гэрлэлтийн байдал, улс төрийн үзэл бодол, бэлгийн чиг хандлага болон нийгмийн гарлыг үл харгалзан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хувь хүний чадварын давуу талд нь үнэлэх замаар ажилд сонгон авч, адил хөдөлмөр эрхэлж буй ажилтнууд болон ирээдүйн ажиллагсдад тэгш шан хөлс олгож, тэгш боломж, хандлагыг дэмжиж ажиллана.

4.5. Ажиллагсдын эрүүл мэнд, аюулгүй байдал

ЖэйСиДеко нь ОУХБ-ын 115 дугаар Конвенцэд заасны дагуу үндэсний болон орон нутгийн ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, журмыг хүндэтгэн сахиж, салбартаа ажлын байрны шилдэг дадал хэрэгжүүлж ажиллах болно.

4.6. Ажлын өдөр ба Ажлын долоо хоногийн үргэлжлэх хугацаа

ЖэйСиДеко нь ОУХБ-ын 30 дугаар Конвенцэд заасны дагуу үндэсний болон орон нутгийн хууль, журамд заасан ажлын өдрийн үргэлжлэх хугацааны хязгаарлалт болон илүү цагаар ажиллуулахтай холбоотой журмуудыг хүндэтгэн дагаж мөрдөх болно.

ЖэйСиДеко нь ОУХБ-ын 14 ба 106 дугаар Конвенциудад заасны дагуу үндэсний болон орон нутгийн хууль, тогтоомжийн дагуу зөвшөөрсөн тодорхой хугацаагаар амралт олгохоос бусад тохиолдолд ажилтан бүрд долоо хоногт хамгийн нэгээс багагүй өдрийн амралт олгох болно.

4.7. Шударга цалин хөлс авах эрх

ЖэйСиДеко нь:

- › Үндэсний болон орон нутгийн хууль тогтоомжид заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний шаардлагыг хангасан буюу үүнээс илүү гарсан цалин хөлсний бодлого баримтална;
- › Бүх ажилтанд цалин олгох бүрд цалингийн хуудас өгнө;
- › Ажилтан бүрд хамгийн багадаа тэдний ажиллаж буй улсын хувьд тодорхойлсны дагуу үндсэн хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц хэмжээний цалин хөлс олгоно.

4.8. Цалинтай амралт авах эрх

ЖэйСиДеко нь ОУХБ-ын 132 дугаар Конвенцэд заасны дагуу хамааралтай тохиолдолд хамтын хэлэлцээ болон бусад холбогдох дүрэм, журмаас хамаарч ажилласан хугацааны доод хязгаарыг тогтоосны дараа бүх ажилтнууддаа ажлын нэг жилд хамгийн доод тал нь ажлын гурван долоо хоногийн хугацаатай цалинтай амралт эдлүүлнэ.

4.9. Сургалтад хамрагдах эрх

ЖэйСиДеко нь ажилтнуудаа шаардлагатай сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хамруулна.

4.10. Бүх хэлбэрийн дарамт, хүчирхийллийг хориглох

ЖэйСиДеко нь ажилтан бүр хүндэтгүүлж, ёс зүйтэй байдлаар харилцах эрхтэй гэдгийг, мөн түүнчлэн ажилтнуудынхаа хувьд аливаа дарамтгүй ажиллах орчин бүрдүүлэх үүрэгтэй болохоо ойлгож, хүлээн зөвшөөрч байна. ЖэйСиДеко нь аливаа хэлбэрийн дарамт шахалт, дээрэнгүй, дайсагнасан зан авирыг хориглож, хүлээн зөвшөөрөхгүй.

4.11. Бүтцийн өөрчлөлт хийсэн тохиолдолд Ажилтнуудыг шилжүүлэн ажиллуулах

Бүтцийн өөрчлөлтийн улмаас ажлын байрыг хасах шаардлагатай болсон тохиолдолд ЖэйСиДеко нь тухайн улсын холбогдох хууль, журам, практикийн дагуу:

- › Ажилтны ажлын байр хасагдсаны дараа аль болох боломжит түргэн хугацаанд холбогдох хууль тогтоомжоор шаардсаны дагуу ажилтнуудын төлөөлөгчтэй зөвлөлдөнө;

- › Боломжтой тохиолдолд тухайн ажлын байр нь хасагдсан ажилтны ажиллаж байсан газартай газар зүйн байрлалын хувьд аль болох ойрхон байршилд компани дотроо өөр ажилд шилжин ажиллах боломжийг олгоно.

4.12. Хувийн нууц, Хувийн мэдээлэл хамгааллын асуудал

ЖэйСиДеко нь өөрийн ажилтнууд, харилцагч, бусад оролцогч талуудын хувийн мэдээллийн нууцлалыг хадгалах асуудлыг чухалчлан авч үзэх бөгөөд үндэсний болон орон нутгийн холбогдох хууль, тогтоомжийн дагуу гагцхүү үйл ажиллагаа явуулахад шаардлагатай өгөгдөл, мэдээллийг хадгалж үлдэнэ.

4.13. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцох эрх

Ажилтнууд ЖэйСиДеког төлөөлж байгаа эсвэл түүний нэрийн өмнөөс ярьж буюу үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн ойлголт төрүүлэхгүй бөгөөд аливаа бусад этгээдийн эрхийг зөрчихгүй тохиолдолд ЖэйСиДеко нь ажилтан бүрийнхээ олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд (үүнд улс төрийн үйл ажиллагааг багтаах боловч үүгээр хязгаарлагдахгүй) оролцох эрхийг хүндэтгэж ажиллана.

Хэрэв сонгуулийн хугацаа ажлын цагаар таарсан эсвэл ажилтан ажлын хуваариасаа шалтгаалан ажлын цагаас өмнө эсвэл хойно сонгуульд санал өгөх боломжгүй байгаа тохиолдолд ЖэйСиДеко нь бүх ажилтандаа сонгуульд оролцож санал өгөх боломж олгоно.

4.14. Нийгмийн хамгаалалд хамрагдах эрх

ЖэйСиДеко нь Групп үйл ажиллагаа явуулж буй улс бүрд хүчинтэй мөрдөгдөж буй заавал хамрагдах үүрэгтэй нийгмийн хамгаалал/даатгалын системд шимтгэл төлөх болно.

ОУХБ-ын 102 дугаар Конвенцийн дагуу ЖэйСиДеко нь ажилтнуудад тэтгэмж олгохдоо улсын халамжийн системээс олгодог эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвар алдах, өндөр насны тэтгэмжийн хэмжээний хооронд аливаа зөрүү гаргахгүй байх талаар хамгийн боломжит хэмжээнд хүчин чармайлт гаргаж ажиллана.

4.15. Ажил-Хувийн амьдралын тэнцвэртэй байдал

ЖэйСиДеко нь ажилтан бүр ажил, хувийн амьдралаа тэнцвэртэй байдлаар авч явах эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн болно.

4.16. Хувийн шалтгаанаар чөлөө авах

ЖэйСиДеко нь ажилтнууд нь хамтын хэлэлцээ болон бусад холбогдох журмын дагуу тухайн тохиолдлоос хамаарч хувийн болон эрүүл мэндийн шалтгаанаар чөлөө авах эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байна. ОУХБ-ын 103 дугаар Конвенц болон эрүүл мэндийн шалтгаанаар чөлөө авах тухай бусад холбогдох хуулийн дагуу тухайн чөлөөний хугацаанд Компани нь холбогдох ажилтны ажлын байр эсвэл үүнтэй төстэй ажлын байрыг түүний чөлөөний хугацаа дуусаж ажилдаа эргэн орох хүртэл нь хадгалах тал дээр дээд зэргийн хүчин чармайлт гарган ажиллана.

4.17. Хүүхэд төрүүлэхтэй холбоотойгоор хамгаалах эрх

ЖэйСиДеко нь гэр бүлд шинээр хүүхэд төрөх ач холбогдол болон ажилтан бүр хүүхэд төрүүлэхдээ ажлаас чөлөөлөгдөх эрхтэй гэдгийг ойлгон хүлээн зөвшөөрч байна. ЖэйСиДеко нь хуульд заасан ажлаас чөлөө олгохтой холбоотой бүхий л журмыг дагаж биелүүлэх бөгөөд энэ тохиолдолд ажилтан нь холбогдох улсын хууль, тогтоомж, практикийн дагуу зөвшөөрсөн чөлөөний хугацааг хэтрүүлэхгүй байх үүрэгтэй бөгөөд ажилтны ажлын байр эсвэл үүнтэй адил ажлын байрыг хүүхэд асрах чөлөөтэй байгаа эцэг эхийн чөлөөний хугацаа дуусаж ажилдаа эргэн орох хүртэл баталгаатай хадгалах үүрэгтэй.



V | Дүрмийг хэрэгжүүлэх

5.1. Гүйцэтгэх зөвлөлийн үүрэг

ЖэйСиДекогийн хувьд энэхүү Дүрмийн хэрэгжилт нь чухал ач холбогдолтой тул Гүйцэтгэх зөвлөлийн гишүүд нь энэхүү Дүрэм болон энд багтсан нийгмийн үнэт зүйлсийг Группийн хэмжээнд зөвөөр тайлбарлаж ойлгуулах үүрэгтэй болно.

5.2. Дүрмийг тараах

ЖэйСиДекогийн Нийгмийн суурь үнэт зүйлсийн Олон улсын дүрмийг үйл ажиллагаа явуулж буй улсад Компанид шинээр ажилд орох үед нь ажилтан бүрд өгнө. Энэхүү Дүрмийг Группийн дотоод сүлжээний хуудсанд Группийн ажиллагсдын ярьдаг хэд хэдэн хэлээр байршуулах буюу Группийн веб хуудсанд байршуулна, эсхүл Хүний нөөцийн хэлтэс болон Хууль зүйн хэлтсээс ирүүлсэн хүсэлтийн дагуу өгөх боломжтой.

ЖэйСиДеко ЭсЭй болон түүний нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гүйцэтгэх удирдлага, менежерүүд нь ЖэйСиДекогийн Нийгмийн суурь үнэт зүйлсийн Олон улсын дүрмийг албан тушаал, эрхэлдэг ажлаас үл хамаарч ажилтан бүрд өгч танилцуулан, тогтмол хэрэглэж байх явдлыг хангах үүрэгтэй.

5.3. Орон нутгийн салбарын Менежментийн үүрэг хариуцлага

ЖэйСиДеко үйл ажиллагаа явуулж буй улс бүр дэх салбарын удирдлага нь энэхүү Дүрэмд заасан зарчим, стандартуудыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх явдлыг гүйцэлдүүлэх үүрэгтэй. Улс орон бүр дэх салбар нэгжүүд нь эдгээр стандартыг өөрийн нэгж салбарын хэмжээнд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр боловсруулж мөрдөнө. Мөрийн хөтөлбөрт тухайн орон нутгийн стандартууд хамгийн доод тал нь энэхүү Дүрэмтэй нийцэж байгаа, мөн энд заасан ажилтны эдлэх эрхүүдийг хүндэтгэн үзэж байгаа эсэхийг тогтоох аудитын шалгалтын шаардлагыг тусгасан байна.

Ажил олгогч нь компанид ажилд орж буй шинэ ажилтан бүрд энэхүү Дүрмийг өгч танилцуулах үүрэгтэй. Энэхүү Дүрмийг тухайн тохиолдлоос хамаарч аливаа хамтын хэлэлцээрт төлөөлөгчөөр оролцож буй этгээдүүдэд өгч танилцуулна. Дүрмийг ажилтнуудын хэрэгцээнд зориулж дотоод сүлжээнд байршуулна.

Тухайн улсын холбогдох дүрэм, журам, практикаас хамаарч ЖэйСиДекогийн холбогдох салбар нэгж бүр нь энэхүү Дүрмийг биелүүлээгүй зөрчилтэй холбоотой аливаа асуудал, хяналт шалгалтын талаар ажилтнууд чөлөөтэй мэдээлэх боломжийг бий болгосон, зөрчил гарсан тохиолдолд түүнийг арилгах боломж бүрдүүлсэн журмыг баталж мөрдүүлнэ.

5.4. Мэдээлэх журам

Хэрэв ажилтан энэхүү Дүрэмд заасан нийгмийн үнэт зүйлийг дагаж биелүүлэхгүй байна, эсхүл зөрчигдөхөд хүрч болзошгүй байна гэж үзсэн бол толгой компаниуд болон заавар өгөгч компаниудын хариуцлагын тухай 2017 оны 3-р сарын 27-ны өдрийн хуульд заасны дагуу мэдээлэх эрхтэй байна.

Дараах арга хэлбэрээр мэдээлэх эрхээ хэрэгжүүлж болно. Үүнд:

- › Эхний алхам болгож асуудлыг өөрийн шууд удирдлагадаа мэдэгдэх;
- › Дараагийн алхам болгож, хэрэв асуудлыг шууд удирдлага шийдвэрлэх боломжгүй тохиолдолд, эсхүл тухайн буруутай үйл ажиллагаанд шууд удирдлага шууд хамааралтай бол Сэрэмжтэй байдлын хорооны Хэрэг эрхлэх газарт мэдээлнэ;

Энэхүү мэдээллийг Сэрэмжтэй байдлын хорооны Хэрэг эрхлэх газарт дотоод сүлжээ эсвэл цахим хуудаснаас нэвтрэх боломжтой цахим мэдээллийн маягыг ашиглаж эсвэл уг зорилгоор ашиглагдах тусгай утсаар (+ 33 1 30 79 79 11) шууд холбогдох замаар өгөх боломжтой.

Мэдээллийг хүлээн авсан этгээд Зохих хугацаанд хариу өгөөгүй бол тухайн мэдээллийг хуулийн байгууллага, захиргааны байгууллага эсвэл мэргэжлийн холбоодод илгээж болно. хэрэв эдгээр байгууллага мэдээллийг гурван сарын дотор боловсруулаагүй бол хамгийн сүүлийн арга болгож мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоно.

Групп нь энэхүү журмын хүрээнд шударгаар шүгэл үлээсэн этгээдийн өгсөн баримтууд нь үнэн зөв биш эсвэл цаашид аливаа алхам хэрэгжүүлэх шаардлагагүй байсан тохиолдолд ч түүний эсрэг аливаа хориг арга хэмжээ авах эсвэл ажлаас халах, хавчиж, гадуурхах арга хэмжээ авахгүй бөгөөд ийм үйлдэл гаргахыг зөвшөөрөхгүй. Үүний адил, энэхүү журмын хүрээнд мэдээлэл дамжуулсан шалтгаанаар аливаа этгээдийг ажилд шалгаруулж авах үйл ажиллагаа, дадлага эсвэл мэргэжлийн сургалтад оролцоход нь саад болохгүй.





Нийгмийн суурь үнэт зүйлсийн
Олон улсын дүрэм

2020 оны хувилбар

JCDecaux